

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ӨЛГИЙ НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2020.09.13

Өлгий сум
5 дугаар баг

ИНЕГ-ын даргын баталсан 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн ИНЕГ-ын харьяа Баян-Өлгий аймаг дахь Өлгий нисэх буудлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 23/20 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор А.Мөнх-Эрдэнэ, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Б.Болормаа нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг дотоод аудитыг хийсэн.

Нисэх буудлын 2019 оны санхүүгийн тайланд Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газраас аудит хийж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргасан байна.

Ажилчдын хүчээр нисэх буудлын эзэмшлийн бүсийн хашааны элэгдэж хуучирч муудсан, хугарсан хэсгийг нөхөж, өнгийг сэргээн будах ажлыг хийсэн. Мөн хогийн савнуудыг нийтийн эзэмшлийн бүсэд шинээр суурилуулжээ. Зорчигчийн танхимын ариун цэврийн өрөөнд шинээр суултуур, хэрэглэл суурилуулсан байна.

Агуулахын байрны эмх цэгц сайн, бараа материалын хадгалалт хамгаалалт хангалттай түвшинд байна.

Дизель генератор, автомашины хувийн хэргийн хөтлөлтийг бүрэн хийсэн байна.

Нисэх буудлын даргын гаргасан тушаал үг, үсэг, утга, найруулгын алдаатай, үндэслэл хэсэгт хууль, дүрэм, журмын заалтыг буруу бичих, “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ын стандартыг зөрчих зэрэг зөрчлүүд нийтлэг байна.

Авлага барагдуулах талаар авиа компаниудтай хамтарч ажиллаж байгаа ч авлагын үлдэгдэл өссөн байна.

Цагийн бүртгэлийг хянахдаа хариуцлагагүй хандсан, цалинтай чөлөөг ажилласан хоногт оруулж бүртгэлийг гаргасантай холбоотойгоор хоолны үнийн хөнгөлөлтөөр 70,000 төгрөг илүү олгогдсон байна

Дизель генераторуудын мотоцагийн заалтыг тулгасны үндсэн дээр шатахууны тооцоо хийгээгүй.

Дотоод хяналт, шалгалтын баг нь илэрсэн асуудлыг нэгтгэн дүгнээгүй, зөвлөмжийн хэрэгжилтийг гаргаагүй, эргэн хяналт тавиагүй байна.

Баян-Өлгий аймаг дахь нисэх буудлын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл нь 2020 онд төлөвлөсөн 13 ажлаас 10 ажлыг хугацаанд гүйцэтгэсэн боловч төлөвлөгөөний хэрэгжилтийг бичгээр гаргаагүй. Ажлын байр тус бүрээр ажилчдад зааварчилгааг тогтмол өгч зааварчилгааны бүртгэлийн дэвтэрт баталгаажуулж хэвшсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т ...Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно... гэж заасныг зөрчиж шууд худалдан авалт хийсэн.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар Иргэний нисэхийн үндэсний төвд 1, тус нисэх буудалд 15, нийт 16 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА